



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 2424

Чингис хот

Коронавируст халдвар (Ковид-19)-ын болзошгүй
эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "а", 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Дэлүүн болдог" постоор нэвтрэн орж буй иргэдэд шинжилгээ хийх оношлуурын зардалд 6,810,000 (зургаан сая найман зуун арван мянга)-н төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231012031

09. Аймгийн Засаг даргын 2021 оны
дүгээр сарын 09 өдрийн АИШ/1
дугаар захирамжийн хавсралт

Коронавируст халдвар /Ковид-19/-ын болзошгүй
эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай зардлын тооцоо

	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Шаардлагатай хамгаалах хэрэгсэл	
				Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Түргэвчилсэн оношлуур	ширхэг	15,000	454	6,810,000
Нийт дүн					6,810,000